

АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ (МУТС) ЭРСДЭЛТЭЙ ХОЛБООТОЙ НИЙТ МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДҮҮДЭД ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛЭХ НЬ



Олон улсын хэмжээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд Ашгийн бус байгууллага (цаашид “АББ” гэх)-ыг ашиглах тохиолдол багагүй байдаг бөгөөд энэ салбар нь МУТС өндөр эрсдэлтэй салбар юм. Гэвч бүх АББ-ыг өндөр эрсдэлтэй гэж үзэж болохгүй ба мэдээлэх үүрэгтэй этгээдүүд нь АББ-тай бизнесийн харилцаа тогтоохдоо тэдгээрийн МУТС эрсдэлийг үнэлэх шаардлагатай.

Санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид нь шинээр харилцагч/гишүүн болж байгаа АББ-ын МУТС эрсдэлийг үнэлэхдээ зохистой засаглал, санхүүжилтийн эх үүсвэр, үйл ажиллагааны чиглэл, гол удирдлагыг хэрэгжүүлэгч этгээдийн мэдээллийг бүрэн олж тогтоох ёстой. АББ-уудын МУТС эрсдэлд өртөх байдал харилцан адилгүй тул мэдээлэх үүрэгтэй этгээд нь дор дурдсан ойлголтод үндэслэн эрсдэлд суурилсан арга хэмжээ авах шаардлагатай байна. Үүнд:

➤ *Харилцагч АББ-ын эцсийн өмчлөгчийг тогтоох*

Энэ хүрээнд удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо, АББ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч, эсхүл түүнтэй адилтгах албан тушаалтан, удирдах, эсхүл шийдвэр гаргалтад нөлөө бүхий этгээдийг тогтоох ёстой. Энэ зорилгоор мэдээлэх үүрэгтэй этгээд нь тухайн АББ-ын эрх зүйн статус, засаглалын бүтэц, хууль ёсны төлөөлөгчдийн жагсаалт зэрэг мэдээллийг гаргуулж авна.

➤ *АББ-ын санхүүжилт (хандив, Засгийн газрын сан гэх зэрэг)-ыг судлах*

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь АББ-ын хандивлагчийн талаарх мэдээлэл, санхүүжилтийн эх үүсвэр, хөрөнгө босгосон арга, жилийн тайлан, санхүүгийн тайланд тусгасан мэдээллийг олж авна.

➤ *АББ-ын үйл ажиллагааны зорилгыг тодорхой болгох*

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагч АББ-ын эрхэм зорилгын талаарх мэдээлэл, хөтөлбөрийн жагсаалт, холбогдох төсөв, үйл ажиллагаа, үйлчилгээ зэрэг мэдээлэлтэй танилцана.

➤ *АББ-ын нэрээр ашиг олох үйл ажиллагаа эрхэлж байна гэж үзсэн тохиолдолд ашиг шимийг хүртэгч нь хэн болохыг тогтоох*

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагч АББ-ын үйл ажиллагааны тайлан, мэдээ, хөтөлбөрийн жагсаалт, бусад шаардлагатай баримт бичгийг судална. Мөн хөтөлбөрийн тайлан, санхүүжилтийн зарцуулалтыг шалгах ёстой.

➤ *Харилцагч АББ-ын зорилго, үйл ажиллагаанаас хамаарч мэдээлэх үүрэгтэй этгээдээс авахыг хүсэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээг тодорхойлох, хийгдэж болох гүйлгээний давтамж, хэмжээ, газарзүйн байршил (гадаадын төлөөлөгчийн газрын ажилтны цалин, эсхүл донорын шилжүүлэг) зэрэг мэдээллийг цуглуулах*

Үүний тулд АББ-ын бүтэц, зохион байгуулалтын схем, ажилтнуудын нарийвчилсан жагсаалт, үйл ажиллагаа тус бүрийн удирдлагыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгчийн мэдээллийг олж авна.

➤ *АББ нь өөрийн хөтөлбөр, үйл ажиллагаагаа зөвхөн дотоодод хэрэгжүүлдэг эсэх, эсхүл МУТС эрсдэл өндөртэй гуравдагч улс орнуудад үйл ажиллагаа явуулдаг эсэхийг тусгайлан нягтлах*

Мэдээлэх үүрэгтэй этгээд нь АББ-аас үзүүлж буй хөтөлбөр, үйл ажиллагаа,

үйлчилгээний жагсаалт, хөтөлбөр хэрэгжүүлдэг болон үйл ажиллагаа явуулдаг газарзүйн байршил, бүс нутгийн жагсаалт зэрэг мэдээллийг олж авах ёстой. Мөн АББ-ын өндөр эрсдэл бүхий гуравдагч орны санхүүгийн байгууллагатай бизнесийн хамааралтай эсэх мэдээллийг авна.

Анхаарах эрсдэлийн хүчин зүйлс

Харилцагч АББ-ын эрсдэлийг тодорхойлохдоо мэдээлэх үүрэгтэй этгээд нь дараах эрсдэлийн хүчин зүйлсийг заавал анхаарч үзэх нь зүйтэй:

Засаглал ба хяналтыг хэрэгжүүлэх

➤ АББ нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн статустай эсэх;

Засаглалын хэлбэрийг тодорхойлсон болон АББ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч, удирдах зөвлөлийн гишүүд, эсхүл АББ-д хяналт тавих эрх бүхий албан тушаалтныг тодорхойлсон баримт бичиг байгаа эсэх;

➤ АББ-ыг байгуулахад удирдлага болон санхүү хариуцсан ажилтны ур чадварт тавигдах шаардлагын талаар хууль, эрх зүйн зохицуулалт бий эсэх;

➤ Хууль, эрх зүйн баримт бичигт санхүүгийн тайланг жил бүр ил тод байлгах шаардлага тавигддаг эсэх.

Нэр хүндийн/хэвлэл мэдээллийн сөрөг дүгнэлт

➤ АББ болон түүний удирдлагын нэр хүндийн болон холбогдох бусад мэдээллийг олжавах, нотлоход хүндрэлтэй эсэх;

Тухайлбал шинээр байгуулагдсан АББ-ын талаарх мэдээллийг олж авахад хүндрэлтэй тул түр хугацаанд өндөр эрсдэлтэй харилцагчтай адилтган үзэж, нарийвчилсан таньж мэдэх ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой;

➤ АББ-ыг найдвартай, хараат бус эх сурвалжуудаас хэт даврагч үзэл, хэт даврагч үзлийг сурталчлах, алан хядагчдын үйл ажиллагаатай холбогдсон эсэхийг тогтоох;

➤ АББ нь бусад гэмт хэрэг, ялангуяа МУТС-тэй холбоотой хэрэгт холбогдсон эсэхийг найдвартай, хараат бус эх сурвалжаас нягтлах.

Санхүүжилтийн хэлбэр

➤ АББ-ын санхүүжилт ил тод, хариуцлагатай эсэх, эсхүл хяналт тавихад хүндрэлтэй эсэх. Санхүүжилтийн эх үүсвэрийг олон нийтэд ил тод болгон баримтжуулсан эсэх, хөндлөнгийн аудитад хамрагддаг эсэх;

➤ АББ-ын санхүүжилтийн хэлбэр нь МУТС эрсдэлтэй эсэх;

АББ нь бэлэн мөнгөний хандив, крипто хөрөнгө, эсхүл олон нийтийн санхүүжилтээс бүрэн болон ихэнхдээ хамааралтай эсэх, эсхүл хөрөнгийн эх үүсвэрээ төлбөрийн системээр дамжуулдаг эсэх;

➤ АББ-ын санхүүжилт нь МУТС эрсдэл өндөртэй буюу МУТС-тэй тэмцэх стратегийн дутагдалтай гэж тодорхойлогдсон гуравдагч улс орнууд, эсхүл хувийн хандивлагчдаас их хэмжээгээр болон хэсэгчилсэн хэлбэрээр бүрдсэн эсэх.

МУТС эрсдэл өндөртэй болон эрсдэл өндөр гэж тодорхойлогдсон гуравдагч орнуудтай холбоотой харьяаллын бүс дэх үйл ажиллагаа

➤ АББ нь МУТС эрсдэл өндөртэй, эсхүл мөргөлдөөнтэй бүс нутаг, эрсдэл өндөртэй гэж тодорхойлогдсон гуравдагч орнуудад үйл ажиллагаа явуулдаг, тусламж үзүүлдэг эсэх;

➤ Ийм нөхцөлд АББ нь үйл ажиллагаагаа явуулахын тулд гуравдагч этгээд, эсхүл зуучлагчдаар дамжуулж, тухайн үйл ажиллагаа, түүнд хамаарах гүйлгээний шинж чанарыг

тайлбарлах боломжтой эсэх. Энэ хүрээнд АББ нь эдгээр гуравдагч этгээд, зуучлагчид хангалттай хяналт тавьдаг эсэх;

➤ АББ-ын бизнесийн харилцаа нь МУТС эрсдэл өндөртэй, эсхүл эрсдэл өндөртэй гуравдагч орнуудад байрладаг харилцагч байгууллагатай төлбөр тооцоо, гүйлгээ хийх эсэх.

Эрсдэлийг бууруулахад нөлөө үзүүлэх хүчин зүйлсийг анхаарах:

➤ АББ-ын удирдах зөвлөл болон удирдах албан тушаалтны үүрэг, хариуцлагыг тодорхой баримтжуулсан байх;

➤ АББ нь санхүүгийн тайлангаа жил бүр ил тод болгох, хөрөнгийн эх үүсвэр, АББ-ын үйл ажиллагааны үндсэн зорилго, хөтөлбөрөөс ашиг шим хүртэгчдийг тодорхойлсон тайлан гаргах үүрэгтэй байх;

➤ АББ нь хараат бус хөндлөнгийн аудитад хамрагдсан эсэхээ нотлох;

➤ АББ нь найдвартай, хараат бус эх сурвалжийн хүрээнд олон нийтэд нэр хүндтэй байх;

➤ АББ нь Засгийн газар, үндэстэн дамнасан, эсхүл олон улсын байгууллагаас санхүүжилт авдаг бол хөрөнгийн эх үүсвэрийг тодорхой тогтоох боломжтой байх;

➤ АББ нь эрсдэл өндөртэй гуравдагч орнуудтай холбоогүй, эсхүл холбоотой тохиолдолд МУТС эрсдэлийг бууруулах талаар зохих арга хэмжээ авснаа нотлох (тухайлбал АББ-ын МУТС-тэй тэмцэх үйл ажиллагаанд хяналт тавих ажилтныг томилох, журам заавар гарган МУТС эрсдэлийг үнэлэх, АББ-ын эцсийн өмчлөгчийг тодорхойлох);

➤ АББ-ын үйл ажиллагааны улмаас болон эцсийн өмчлөгчөөс шалтгаалан тухайн АББ нь МУТС эрсдэлд өртөхгүй байхаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан;

➤ АББ нь мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгслээр хангах зэрэг хувь хүмүүст шууд материаллаг тусламж, дэмжлэг үзүүлдэг байх.

Мэдээлэх үүрэгтэй этгээд та дээрх зааврын дагуу өөрийн үйлчилгээ үзүүлж буй АББ-уудын эрсдэлийг үнэлэн, МУТС эрсдэлийг бууруулж ажиллахыг зөвлөж байна.